

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТӨВИЙН 2024 ОНЫХАГАС ЖИЛИЙНГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024-06-30

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ ТУСГАГДСАН ЗОРИЛТ							
Гүйцэтгэлийн зорилт:1.1 Ажиллагсад болон үйлчлүүлэгчдэд ээлтэй орчинг бүрдүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжруулж ажиллана							
1.1.1	Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2021-2025) 2.2.2, 2.2.3	БӨХ	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот хөтөлбөр (“Эрүүл идэвхтэй амьдрал”) зэрэг арга хэмжээнүүдийг өөрийн тусламж үйлчилгээнд зохицуулан хэрэгжүүлж ажиллана.	80%	85%	“Энэ жил эрүүл жиндээ-2, “Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулж эрүүл зан үйлийг хэвшүүлье-2” аяныг эхлүүлж байгаатай холбогдуулан байгууллагын хүрээнд 2024 оны 04 дугаар сарын 09-ны өдөр Богд-Өлзий өрхийн эрүүл мэндийн төвийн НЭМ-н арга зүйчтэй хамтран 20 ажилтны биеийн жинг тодорхойлов. Үүнд: ➢ Хэвийн жинтэй 6 ажилтан ➢ Илүүдэл жинтэй 10 ажилтан ➢ Таргалалтай 4 ажилтан байна. Ажилчдын биеийн жинг өмнөх жилтэй харьцуулж үзэхэд биеийн жингийн үзүүлэлт өмнөх үзүүлэлтээс 10%-иар буурсан ахиц гарсан байна. “Амар-амьдрал” төрийн бус байгууллагын тэргүүн сургагч багш Д.Оюунтай гэрээ	100

					хийж өглөө бүр үйлчлүүлэгч нарт хоол, дасгал хөдөлгөөн, бясалгал, идээ ундаа, явдал мөрийн сургалтыг 10 минут, дасгал хөдөлгөөнийг 20 минутад хийж хэвшсэнээр эрүүл идэвхтэй амьдрах зан үйлд бүх үйлчлүүлэгчдийг хамруулж байна. “Уламжлалт анагаах ухааны аргаах хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга барилтай болгох, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг эзэмшүүлэх” зорилгоор IV дүгээр сургуулийн ажилчдад уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлж сургалт сурталчилгаа зохион байгуулсан. ЕБС-ийн 3 сургуулийн 66 ангийн 31 сурагчдад “Ус ба энхтайван” сэдвээр 40 минутын сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулж, гарын авлагаар ханган ажилласан.Сургалтын дараа асуулт, хариултын тэмцээн явуулж нэгдүгээр байр эзэлсэн сурагч Гантигмааг шагнаж урамшуулсан.	
--	--	--	--	--	---	--

						 Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил"-ийн нээлтийн үйл ажиллагаанд 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 07 цагт эрүүл мэндийнхээ төлөө алхангаа ярилцъя алхалтад байгууллага хамт олноороо идэвхтэй оролцсон. 	
--	--	--	--	--	--	---	--

1.1.2		БӨХ	“Чадварлаг эмч” арга хэмжээг хэрэгжүүлж, эмч эмнэлгийн ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.	70%	100%	Монголын сувилагчдын нийгэмлэгээс хүн ардынхаа эрүүл мэндийг хамгаалах ариун үйлсэд өөрийн эрдэм мэдлэг, авъяас чадвараа зориулж олон жил үр бүтээлтэй ажилласан сувилагч Б.Нямдаваад Ард түмний талархал хүлээсэн “Гавъяат сувилагч” хүндэт тэмдгээр шагнагдсан.  Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах орон сууцны дэмжлэг үзүүлэх журмын дагуу их эмч Э.Сайханжаргал шалгарч 20.0 сая төгрөгийн урамшуулал олгох батламжаар шагнагдсан.  Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Бидний ирээдүй-Бидний сувилагч” Олон улсын сувилагч, Эх баригчдын дэлхийн өдрийг угтан зохион байгуулсан үйл ажиллагаанд Зоонозын өвчин судлалын төвтэй хамтран эрэгтэйчүүдийн волейболын баг оролцож 2 дугаар байр	100
-------	--	-----	---	-----	------	---	-----

						эзэлсэн. Байгууллагын дотоод журмын дагуу 4 ажилтанд 7 хоногийн цалинтай чөлөө олгосон. УАУТ-ийн дарга Д.Өлзийбаяр Улаанбаатар хотод Эмнэлзүй-2024 онол практикийн бага хурал, Эрүүл мэндийн яамны дэргэдэх уламжлалт анагаах ухаан судлалын мэргэжлийн салбар зөвлөл, АШУҮИС-ийн МАУОУС хамтран Баянхонгор аймгийн “Шаргалжуут” рашаан сувилалтай танилцах, туршлага солилцох эмнэлзүйн сургалт, хэлэлцүүлэгт тус тус оролцсон. Уламжлалт бариа заслын сувилагч Ч.Юнрэндорж олон жил үр бүтээлтэй ажилласныг үнэлж Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдсан.	
1.1.3		БӨХ	Стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулна.	0	100%	Уламжлалт анагаах ухааны төвийн хөгжлийн хөтөлбөрийг 2024-2027 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг 5 зорилтын хэмжээнд (Удирдлага зохион байгуулалт, УАУ-ны тусламж Үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, төгсөлтийн дараах сургалтад хамруулах, Нийгмийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх) 30 үйл ажиллагаа төлөвлөн батлуулахад бэлэн болоод байна.	100
1.1.4			Баруун бүсийн уламжлалт анагаах ухааны уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулна.	0	1	Монгол улсын их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой Монголын уламжлалт анагаах ухааны нөлөөлөл-2024 баруун бүсийн аймгуудын зөвлөгөөн, хэлэлцүүлэг	

						хойшлогдсон ба 2024 оны 07 дугаар сарын 6-8-ны өдрүүдэд хийхээр төлөвлөж бэлтгэл ажлуудыг хангаад байна.	
1.1.5	ЭМХТ-ийн 2022 оны 1152 албан бичгийн дагуу шинжээчдийн багийн зөвлөмж		Ажилчдын дунд “Ажилтан бүр судлаач” эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулна.			Уламжлалт анагаах ухааны төвөөснэг жилийн хугацаанд зарласан “Ажилтан бүр судлаач” аяны хүрээнд ➤ Сувилагч Г.Ариунтуяа “Голын хий өвчнийг бариа заслаар эмчлэн дүнг тооцох нь” ➤ Эм найруулагч Б.Бямбажав “Монгол эмийн хадгалалт хамгаалалт түүнд тавих хяналт үр дүнг тооцох” ➤ Сувилагч Д.Бүжинлхам “Харандаан төөнө заслаар хаван буулгах нь” ➤ Сувилагч С.Мядагмаа “Мартах хам шинж бүхий өвчтөн ба хөдөлмөр засал эмчилгээ” ➤ Сувилагч Б.Нямдаваа “Ясны ургалтад шавар болон физик эмчилгээ хийж харьцуулан судалж үр дүнг тооцох нь” ➤ Сувилагч Юнрэндорж “Тархи дорголтыг бариа заслын арга болон эмийн эмчилгээтэй харьцуулан судлах нь” зэрэг сэдвүүдээр эрдэм шинжилгээ судалгааны ажил хийхээр төлөвлөн гүйцэтгэл 50%- тай явж байна.	

1.1.6	ЗГ-ын Үйл ажиллаганы хөтөлбөр(2020-2024) 1.1.3.1, 1.1.3.3	БӨХ	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.	70 %	80%	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэн ажиллахад эмийн нөөцөд 85 нэр төрлийн 2100.0 мянган төгрөгийн эм тариа, хувцас хэрэгслийн нөөцтэй байна.	100
1.1.7	Завхан аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	БӨХ	Тусламж үйлчилгээний төрөл, кабинетүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих шалгуур, хяналтын хуудсанд хяналт тавьж хэрэгжилтийг ханган ажиллана.	5	8	Тусламж үйлчилгээний төрөл, кабинетүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих шалгуур, хяналтын хуудсыг чанарын баг 10, сувилахуйн баг 17, халдвар хамгааллын баг 11 үзүүлэлтээр тус тус хяналт тавьж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ээлжийн сувилагч нараас бүтэн биеийн бариа засал 93,9%, эмч нараас ижил мэргэжилтний үнэлгээ өвчний түүх бичилт 100%, зүү эмчилгээ 90%, нягтлан бодогчийн ажлын гүйцэтгэл 100%, нярав ажлын гүйцэтгэл 91,6%, хүний нөөц бичиг хэргийн ажилтан 90%, тогооч 94%, сантехникч- цахилгаанчин ажлын гүйцэтгэл 77.7%, үйлчлэгчийн ажлын гүйцэтгэл 86,6% тус тус үнэлэгдсэн.	100
1.1.10	ЭМХТ-ийн 2022 оны 1152 албан бичгийн дагуу шинжээчийн багийн зөвлөмж	БӨХ	Үйлчлүүлэгчийн эрх үүргийг баталгаажуулсан журам боловсруулж сургалтыг тогтмолжуулна. Цаг товлох үйлчилгээний бүртгэлд үр дүнг тооцож ажиллана.	0	100%	Цаг товлох үйлчилгээг эхний улиралд 451 хүн очер бичүүлснээс 425 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн ба 26 үйлчлүүлэгч нь ар гэрийн шалтгаанаар хэвтээгүй болно. Хэвтэн эмчлүүлэгчдийн биеийн байдал сайжирсан нь сэтгэл ханамжийн судалгаагаар 100 хувь үнэлэгдсэн байна.	100

Дундаж хувь							100%		
ХОЁР.ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ									
Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: 2.1 Төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй чанартай хүргэх									
2.1.1	Завхан аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	БӨХ	Чанарын хаалганы байгуулна.	аян, өдөрлөг	нээлттэй зохион	3	4	Уламжлалт анагаах ухааны төвийн эмч, эмнэлгийн ажилчид “Уламжлалт анагаах ухааны аргаар хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга барилтай болгох, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг эзэмшүүлэх” зорилгоор IV дүгээр сургуулийн ажилчдад уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлж сургалт сурталчилгаа зохион байгуулав. Мөн Уламжлалт анагаах ухааны төвийн дарга Д.Өлзийбаяр “Уламжлалт анагаах ухааны талаар” сургалт явуулав. Үйл ажиллагаанд нийт 52 хүн хамрагдаж үзлэг оношилгоо, зөвлөгөө мэдээлэл өгсөн. Мөн бумба 15 хүнд, хэсгийн бариа 48 хүнд хийж үйлчилсэн байна. Эрүүл мэндийн газраас үүрэг чиглэл өгсний дагуу уламжлалт анагаах ухааны төвийн эмч, эмнэлгийн ажилчид “Уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалья” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Хүүхэд гэр бүл хөгжлийн хамгааллын газарт Эрүүл мэндийн газар, АНЭ-ийн уламжлалтын тасаг, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулсан. Уламжлалт анагаах ухааны төвийн дарга Д.Өлзийбаяр “Уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалья” сэдвээр илтгэл тавьсан. Уг үйл ажиллагаанд нийт 68 хүн хамрагдаж, үүнээс 48 үйлчлүүлэгч нь	100

үзлэг оношилгоо хийгдэж, өдөрлөгт хамрагдсан үйлчлүүлэгчдэд “Уламжлалт анагаах ухааны өвчнөөс урьдчилан сэргийлэх ёс”, “Зөв зохистой хооллолт”, “Идээ ундаагаа хэрхэн зохицуулж хооллох”, “Өвчин болох ёс”, “Таван цулын ач тус”, “Уламжлалт эмчилгээний үед барих гам цээр”, “Монгол эмийн тухай ойлголт”, “Идээ ундаагаар өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх ёс”, “Хүний биед улирал хэрхэн нөлөөлдөг” зэрэг сэдвүүдээр брошур хийж 50 гаруй үйлчлүүлэгчдэд өгсөн.

Мөн уламжлалт эмчилгээний хоолны танилцуулга, амталгаа хийсэн. Үүнд.

1. Гүзээний зутан шөл
2. Таван цулын хуушуур
3. Хонь болон үхрийн элгээр хучмал, нухаш, котлет
4. Аарц гэх мэт



2.1.2		БӨХ	Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээг стандарт удирдамжийн дагуу багаар үзүүлдэг байх чадварт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургана.	20%	50%	Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн их эмч Баярмаа яаралтай тусламж үзүүлэх гардан үйлдлүүдээр ажлын байрны сургалтыг явуулж их эмчийн мэдвэл зохих чадвар дадлыг бий болгож чадваржуулсан. 8 сувилагчийг нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн их эмч Баярмаа яаралтай тусламж үзүүлэх үед хэрхэн ажиллах талаар гардан үйлдлүүдийг эзэмшүүлэх ажлын байрны сургалтыг явуулж сувилагчийн мэдвэл зохих чадвар дадлыг бий болгож чадваржуулсан.	100
2.1.3		БӨХ	Яаралтай тусламжийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж эм, эмнэлгийн хэрэгслэл, нөөцийн бэлэн байдлыг хангаж ажиллана.	75%	80%	Эрүүл мэндийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/197 дугаар жагсаалтын дагуу яаралтай эм тарианы журналыг шинэчлэн боловсруулж, эм тариаг ханган ажиллаж байна. “Яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах нь” сэдэвт сургалтыг бүх ажилчдад 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдөр хийсэн. Цочмог өвдөлтийг намдаах яаралтай үеийн зүү эмчилгээ, толгойн өвдөлт болон нойргүйдлийг бүлээн зүү эмчилгээгээр эмчлэх шинэ санааг авч хэрэгжүүлж үр дүнг тооцон ажиллаж байна. Нойргүйдэл гэсэн зовиуртай 10 хүнд толгойн оройн цэгт бүлээн зүүг 3 удаа тавьж үр дүнг үнэлэхэд шөнө 2-3 цаг унтдаг гэсэн 5 хүний унтах цаг нэмэгдэж 5-6 цаг болсон.	100

						5 цаг унтдаг гэсэн 4 хүний унтах цаг 6-7 цаг болж нэмэгдсэн.Огт унтаж чадахгүй нойр сэргэлздэг гэсэн 1 хүн шөнөдөө 5 цаг унтдаг болсон ба 100 хувь үр дүн гарсан. Толгойн өвдөлттэй 5 хүнд халуун бүлээн зүү тавьсан.Үүнээс өвдөлтийн шугаман үнэлгээгээр: Хүчтэй өвдөлттэй буюу 8 оноогоор 2 үйлчлүүлэгч, дунд зэрэг өвдөлттэй буюу 6 оноогоор үнэлэгдсэн 3 үйлчлүүлэгч байсан. 2 удаагийн зүү эмчилгээний дараагаас 8 оноогоор үнэлэгдсэн 2 үйлчлүүлэгч бага зэрэг өвдөлттэй буюу 4 оноогоор, 4 оноогоор үнэлэгдсэн 3 үйлчлүүлэгчээс өвдөлтгүй буюу 0 оноогоор үнэлэгдсэн 1, зовиур мэдрэгдэж байгаа буюу 2 оноогоор үнэлэгдсэн 2 үйлчлүүлэгч байсан. Нийт 5 удаагийн бүлээн зүү эмчилгээний дараа бүгд толгойн өвдөлтгүй буюу 0 оноогоор үнэлэгдэж бүлээн зүү эмчилгээ 100 хувь үр дүнгээ өгсөн гэж үнэлж байна.	
2.1.4		БӨХ	Оношилгоо эмчилгээнд шинэ технологи нэвтрүүлэн мөрдөж ажиллана.(Улирлын хөдлөл зүйтэй гариг эрхэсийн эмгэгтэй ад дон лусын гаралтай өвчтөнд гүрэм, ном засал эмчилгээ хийж ажиллана)	40%	80%	Лам Батболдтой гэрээ байгуулан хэвтэн эмчлүүлж байгаа улирлын хөдлөл зүйтэй гариг эрхэсийн эмгэгтэй ад дон лусын гаралтай өвчтөнд гүрэм, ном засал эмчилгээг 10 хоног тутамд 1, нийт 18 удаа хийж ажилласан.	100
2.1.5			Уламжлалт анагаах ухааны эмчилгээг хөдөлгөөн засал эмчилгээтэй хослуулан	3	6	Үйлчлүүлэгчдийн дунд бүсэлхий нурууны өвдөлтийн нэг шалтгаан нь булчингийн чангарал нуруу болон суудлын мэдрэл	100

			хөгжүүлнэ.			дарагдаж, гуяны хажуу болон ар хэсэгрүү бадайрч өвдөх шалтгаан юм. Нурууны булчин суллах дасгал, нурууны сунгалтын дасгалыг 174 үйлчлүүлэгчид хийсэн. Хүзүүний булчинг суллах дасгалыг 152, өвдөгний үений хөдөлгөөн засал эмчилгээг 39 үйлчлүүлэгчид тус хийсэн. Сэргээн засах, Хөдөлмөр засал эмчилгээг нугасны гэмтэл, тархины цус харвалттай 124 үйлчлүүлэгчид хийсэн.	
2.1.6	ЭМХТ-ийн 2022 оны 1152 албан бичгийн дагуу шинжээчийн багийн зөвлөмж		Сувилахуйн эмнэл зүйн хэлэлцүүлгийг улирал тутам хийж хэвшүүлнэ.	2	4	Сувилахуйн эмнэл зүйн хэлэлцүүлгийг “Сувилахуйн тусламж үйлчилгээг чанар хүртээмжтэй үзүүлэхэд нөлөөлж буй эрсдлүүд” сэдвээр 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр сувилагч мэргэжилтнүүдийн дунд сургалтын өрөөнд зохион байгуулсан.Үүнд: 1.Сувилахуйн мэргэжилтнүүдийн ажлын ачаалалд үнэлгээ хийж сувилагчийн ажлын зураглал гаргасан. 2.Шинээр 2 сувилагч авч дадлагажуулан ажиллуулсан. 3.Ижил нэртэй андуурагдах эмнүүдийн жагсаалт гарган сувилагч нарт сургалт явуулан гарын авлагатай болгож тарианы өрөөнд ил байршуулсан. 4.Сувилагч нарын илүү цагийг тогтмол бодож хийсэн ажлын шалгуурын дагуу үнэлэн урамшуулах, хөдөө орон нутгийн нэмэгдэлд хамруулан ажилласан.	100
2.1.7	Байгууллагын дотоод журам		“Кальцитай шөл”, “Уушиг зүрхний бөөрөнцөг” хийж байгууллагын брэнд хоол бий болгоно.	0	50%	Ахлах тогооч А.Хажидмаа, тогооч Д.Баярмагнай нар “Кальцитай шөл”, “Уушиг зүрхний бөөрөнцөг”-ний технологи картыг шинэчлэн	100

						баталгаажуулж, хэвтэн эмчлүүлэгч болон өөрсдийн ажилчдад “Кальцитай шөл” - өөр 70 хүнд, “Уушиг зүрхний бөөрөнцөг”-ийг 100 гаруй хүнд тус тус үйлчилж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар сайн үнэлгээ авсан.	
2.1.8	ЭМС-ын 2022 оны А/352 дугаар тушаал		Үйлчлүүлэгчийг унах бэртэх эрсдэлээс сэргийлэх анхааруулга зааварчилгааг өгч ажиллана.	50%	70%	Үйлчлүүлэгчийг унах бэртэх эрсдэлээс сэргийлсэн 2 самбар, үзүүлэх маягт, таних тэмдэглэгээ, анхааруулгыг шаардлагатай цэгүүдэд байршуулж ажиллаж байна. Таних тэмдгийг 13 үйлчлүүлэгчдэд зүүж эрсдлээс сэргийлж ажилласан.	100
2.1.9	ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаал		Шинэ ажилтанг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан байна.	0	100%	Шинээр ажилд орсон сувилагч Ц.Пүрэвсүрэн, их эмч Б.Сосорбурам нарыг аймгийн нэгдсэн эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт 14 үзүүлэлтээр үзүүлэн үр дүнг тооцон ажиллаж байна.	100
2.1.10	ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаал		Тусгаарлах өрөөг стандартын дагуу ажиллуулна.	50%	100%	Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалын дагуу тусгаарлах өрөөг стандартын дагуу тохижуулсан байгаа.	100
2.1.11	ЭМХТ-ийн 2022 оны 1152 албан бичгийн дагуу шинжээчийн		Халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн үед үзүүлэх тусламж үйлчилгээний сургалтыг зохион байгуулж бүх ажилчдад дадал хэвшлийг бий болгож ажиллана.	0	22	Байгууллагын бүх ажилчдад халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн үед үзүүлэх тусламж үйлчилгээний сургалтыг 1 удаа зохион байгуулж ажилласан.	100
2.1.12	багийн зөвлөмж		Эрүүл мэндийн ажилтны гарын эрүүл ахуйн байдалд хяналт, үнэлгээ хийж үр дүнг тооцон	4	12	Эрүүл мэндийн ажилтны гарын эрүүл ахуйн байдалд хяналт, үнэлгээ хийж үр дүнг тооцон ажилласан.	100

			ажиллана.				
2.1.13	MNS5700:2020" стандарт, Монгол улсаас "Гамшгаас хамгаалах тухай" хууль	БӨХ	Гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх төлөвлөгөөтэй ажиллана.	70%	90%	Жил бүр "Гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ"-ний талаар нөхөн сэргээх төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж байгаа.	100
2.1.14	MNS5700:2020" стандарт	БӨХ	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм заавартай, сургалт явуулдаг санамжийг холбогдох ажлын байран дээр байрлуулж, хяналт тавьж ажиллана.	80%	90%	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм, заавартай, сургалт явуулдаг, санамжийг холбогдох ажлын байран дээр байрлуулж, хяналт тавин ажиллаж байна.	100
2.1.15	MNS5700:2020 стандарт, ЭМС-ын 2018 оны А/344 дүгээр тушаал	БӨХ	Тоног төхөөрөмжийг ашиглах ажиллуулах болон аюулгүй ажиллагааны сургалтыг хийж, техник ашиглалтын паспортыг тогтмол хөтөлнө.	60%	90%	Байгууллагын хэмжээнд мөрддөг галын аюулгүй ажиллагааны батлагдсан заавартай, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. 2024 оны 3 дугаар сарын 2-ны өдөр ажилтан М.Батчулуунаар "Физик эмчилгээний багаж тоног төхөөрмжийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа" сэдвээр ажилчдад сургалт зохион байгуулсан. Мөн 2024 оны 7 дугаар сард ОБГазартай хамтран галын аюулгүй байдлын дадлага, сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн.	
2.1.16	MNS5700:2020" стандарт, Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015"	БӨХ	Эм зүйн тусламж үйлчилгээнд мөрддөг дүрэм, журамтай, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	20%	50%	Тасагт эм олгох болон эмийн гаж нөлөөг бүртгэх журмуудыг батлуулан мөрдөн ажиллаж байна. Одоогоор илэрсэн зөрчил байхгүй. Хагас жилийн байдлаар эмийн сангийн тооллогыг хийхэд 70 нэр төрлийн 20 гаруй сая төгрөгийн эм тан болон	

						яаралтай тусламжид хэрэглэгдэх европ эмнүүд байгаа.	
2.1.17	ЭМС-ын 2019 оны 566 дугаар тушаал, ЭМС-ын 2020 оны А/625 тоот тушаал	БӨХ	Эм зүйн тусламжийн хүрээнд чанар аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулж, дүн шинжилгээ хийнэ.	2	4	Чанар аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг 3 чиглэлээр боловсруулсан. Манай эмнэлэгт хэрэглэгдэж байгаа эм тангууд нь тайлангийн хугацаанд эрүүл мэндийн нийт тусламж авсан тохиолдлуудаас үзэхэд гаж нөлөө илрээгүй байна. Мөн хугацаа дууссан 5 нэр төрлийн 3600 ширхэг эм танг өмч хамгаалах баг болон чанарын багуудтай хамтран устгалд оруулсан.	100
Дундаж хувь							100%
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: 3.1 Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах							
3.1.1	МУАУ-ны НЭ-ийн стандарт MNS 5700:2020		Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг өргөжүүлж батлагдсан орыг бүрэн ашиглана.	Орны фонд ашиглалт	Орны фонд ашиглалт	Үйлчлүүлэгчдэд уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтэн эмчлүүлэх тасаг гэсэн 2 чиглэлээр үзүүлж, эрүүл мэндийн газраас баталсан өдрийн 5 ор, хэвтүүлэн эмчлэх 35 ороор ажиллаж яаралтай тусламж, тусгаарлах өрөөг гарган 24 цагаар ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр эмчлүүлсэн хүний тоо 887, ашигласан ор хоног 6167, дундаж ор хоног 7.0, орны фонд ашиглалт 178, орны эргэлт 26 байна. Амбулаторийн үзлэг 1496, өдрийн эмчилгээ 237 байна.	100
3.1.2	Эрүүл мэндийн тухай хууль		Байгууллагын мэдээ мэдээллийн тайланг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх,	12	12	Тусламж үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаанд мэдээллийн сангийн баяжилтыг тогтмол хийн статистик	100

			мэдээний санд баяжилт хийнэ.			мэдээг 5 чиглэлээр сар бүр нэгтгэн ЭМГ-т мэдээллэсэн. Мэдээ хоцроосон зөрүүлсэн зөрчил үгүй. Мэдээ өгсөн тоо-6 2024 оны мэдээг hinfostata мэдээллийн сангийн баазад шивж баяжилт хийсэн. Сар бүрийн мэдээг мэдээллийн сангийн цахим программд шивж баталгаажуулсан.	
3.1.3	ЭМ-ийн тухай хууль 20.2.7		Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах сургалтад хамруулна.	80%	90%	“Хөх Бидэр Бариа заслын сургалтын төв”-тэй 3 сарын хугацаатай гэрээ байгуулан суралцуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. БНХАУ-ын ӨМӨЗО-ы Олон улсын монгол эмнэлэг, МУ-ын ЭМЯ-ны ЭМХТ-тэй хамтран зохион байгуулсан “Дундад улс-монгол улсын монгол эм эмнэлгийн тусгай мэргэжлийн чадвартны олон улсын сургалт”-д 2024 оны 5 дугаар сарын 18-аас 6 дугаар сарын 03-ны өдөр хүртэлх хугацаанд дарга Д.Өлийбаяр хамрагдсан. Эрүүл мэндийн яамнаас 2024 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан арга зүйч Бямбажавыг НЭМ-ийн арга зүйч нарыг чадавхижуулах сургалтад хамруулсан. Сувилахуйн амьдрал төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Уламжлалт анагаах ухааны эмч судлаачдын нийгэмлэгээс зохион байгуулагдсан багц цагийн сургалтуудад эмч, эмнэлгийн	100

						мэргэжилтнүүдийг хамрагдсан.	
	ЭМХТ-ийн 2022 оны 1152 албан бичгийн дагуу шинжээчийн багийн зөвлөмж		Хөдөлгөөн засалч С.Мядагмааг харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд харилцах чадварт сургана.	0	1	Хөдөлгөөн засалч С.Мядагмаа нь харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдтэй харилцах чадварыг бие даан суралцаж байгаа.	
			Нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааг үйлчлүүлэгчдэд тогтмол хийж, гарын авлагаар ханган ажиллана.	50%	70%	Уламжлалт анагаах ухааны төвийн эмч ажилчид 2024 оны 03 дугаар сарын 12- ны өдөр аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн ажилчдад “Уламжлалт анагаах ухааны аргаар хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга барилтай болгох, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг эзэмшүүлэх” зорилгоор нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж сургалт сурталчилгаа зохион байгуулсан. Үйл ажиллагаанд нийт 52 хүн хамрагдаж үзлэг оношилгоо, зөвлөгөө мэдээлэл өгсөн. Мөн бумба 15 хүнд, хэсгийн бариа 48 хүнд хийж үйлчилсэн. Нийгмийн хариуцлагын хүрээнд IV дүгээр сургуулийн 4 албан хаагчид уух эм танг нь үнэгүй өгсөн. 	100

3.1.4			Шинэ ажилтанг чиглүүлэх, өөрийн эмнэлэгт баримжаа олгох сургалтын зохион байгуулна.	60%	80%	Байгууллагын даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар батлагдсан “Аилтан сонгон шалгаруулж ажилд авах, сурган дадлагажуулах журам”-ын дагуу их эмч Э.Одгэрэл шинээр ажилд орсон их эмч Б.Сосорбурамыг 2024 оны 05 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд 5 хоног дагалдан хийлгэж Уламжлалт анагаах ухааны төв эмнэлэгт баримталж буй хууль тогтоомж, Эрүүл мэндийн сайдын тушаалууд, хэрэгжиж буй тушаал шийдвэрүүд, ажлын байранд хийх ажилтай нь танилцуулсан. Мөн истори бичих болон анхан шатны маягт хөтлөх, гардан үйлдэл зүү, төөнө, хануур, самнуур, шивүүр засал хийхэд сургаж сувилагч тусгай мэргэжилтэн, үйлчлэгч нарын ажлыг хянах зөвөлгөө өгөх талаар зааж сургаж (уламжлалтын их эмчийн сорил 14 тестээр) шалгалт авахад 81,4 хувьтай үнэлэгдсэн ба Эрүүл мэндийн сайдын хамгийн сүүлд мөрдөгдөж байгаа халдварын сэргийлэлт хяналтын заавар, хануур, зүү засал эмчилгээний тушаал, шийдвэрүүдийн талаар 10 асуултаар асуумж авахад 25 хувьтай үнэлэгдсэн ба цаашид уншиж судлах шаардлагатай байна. Эрүүл мэндийг хуудсыг асуумжийн дагуу бөглүүлж авсан.	100
			Хүний нөөцийг ажлын байран дээр тасралтгүй сургах нөхцөл, боломжоор ханган сургалтын	70%	90%	Хүний нөөцийн ажилтан Д.Сайнбилэг шинэ ажилтныг сургах дадлагажуулах хяналтын хуудсаар их эмч	

			төлөвлөгөө гарган ажиллана.			Б.Сосорбурамыг1-5 оноогоо үнэлж дүгнэсэн.Үүнд: ➤ Байгууллагын дотоод дүрэм журмууд ➤ Албан тушаалын тодорхойлолт ➤ Хөдөлмөрийн гэрээ ➤ Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа ➤ Байгууллагын соёл, харилцаа хандлага Төрийн албан хаагчийн хувийн хэрэгт байх үндсэн баримт бичгийн жагсаалтын талаар ажлын байрны сургалт хийж гарын үсгээр баталгаажуулсан.	
	Өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль		Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх мэдээ, тайланг хугацаанд нь хүргүүлнэ.	85%	88%	Төрийн үйлчилгээ, захидал, эрүүл мэндийн зөвлөгөө, санал хүсэлт, өргөдөл, гомдол, хүлээн авах цагийн хуваарь, ажилтны утасны дугаар, и-мэйл хаяг зэргээр үйлчлүүлэгчдэд мэдээлэл өгөх журмын дагуу мэдээллийг хүргэн ажиллаж байна.	100
Дундаж хувь							100%
Дөрөв. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 4.1 Байгууллагын дотоод хяналтыг сайжруулан, төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган өр авлагагүй ажиллаж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн үр ашигтай зарцуулан ажиллана.							
4.1.1	ЭМС АЗД-тай хамтран ажиллах гэрээний 3.2.17	БӨХ	Байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон ажиллана.	өр авлага гаргаагүй	Өглөггүй ажиллан а.	Төсвийн хөрөнгийг хуваарьт зүйл ангид нь зарцуулан сар бүр тайлан мэдээг гаргаж холбогдох газруудад тайлагнан тооцоо нийлж ажилласан. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 66900,0 /жаран зургаан сая нэг зуун мянган/ төгрөгийн	100

						авлагатай.	
4.1.2	Төрийн албаны тухай хууль	БӨХ	ЗГ-ын тогтоол шийдвэр, холбогдох хуулийн заалтуудыг танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	100%	100%	Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 6, 10, 11 дүгээр хавсралт, 02 дугаар сарын 28-ны өдрийн 84 дүгээр тогтоолын 1, 3 дугаар хавсралтуудыг бүх ажилчдад танилцуулсан.	100
4.1.3	ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тушаал	БӨХ	Байгууллагын дотоод хяналт шинжилгээ, үнэлгээг график төлөвлөгөөний дагуу хийнэ.	70%	100%	Дотоод хяналтын баг нь 2024 онд хийх ажлын графикт төлөвлөгөөг гарган баталгаажуулан ажиллаж байна.	100
Дундаж хувь							100
Тав.Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт							
Гүйцэтгэлийн зорилт 5.1Байгууллагын ил тод байдлыг ханган ажиллана							
5.1.1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6-р зүйл	БӨХ	Мэдээллийн ил тод байдал байдлыг ханган цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчлэн ажиллана.	85	90	Эрүүл мэндийн даатгал болон санхүүжилт, дүн бүртгэлийн талаарх мэдээ мэдээллийн ил тод, харагдахуйц байдлаар байршуулан ажилчид болон үйлчлүүлэгчдийг тогтмол мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. Мэдээллийн ил тод байдлыг ханган цахим болон мэдээллийн самбарт байрлуулан тогтмол шинэчлэн ажилласан.	100
5.1.2	Шилэн дансны тухай хуулийн 5, 6 дугаа зүйл ЗГ-ын 2016 оны 29-р тогтоол	БӨХ	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангана.	95%	96%	Санхүүгийн тайлан мэдээг хуулийн хугацаанд нь шилэн дансанд болон байгууллагын ил тодын самбарт байрлуулан ойлгомжтой байдлаар байрлуулан иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжоор ханган ажиллаж байна.	100

5.1.3	Төсвийн тухай хууль тогтоомж, Шилэн дансны тухай хууль	БӨХ	Байгууллагын үр ашиггүй зардлыг багасгаж, төсөвт өр үүсгэхгүй, төсвийг үр дүнтэй зарцуулж, ил тод нээлттэй байдлыг ханган, ОНХС, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан тайлагнана.	90%	шилэн дансанд хугацаанд нь байршуулсан байна.	Хагас жилийн санхүүжилт, төсөв бүрдүүлэлтэнд дүн шинжилгээ хийж аль болох үргүй муу зардал гаргахгүй байхыг хичээж төсвийн зүйл ангийг үр ашигтай зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Байгууллагын санхүүтэй холбоотой мэдээллийг шилэн дансанд хугацаанд нь бүрэн байршуулж хэвшсэн. Төсвийн хөрөнгийг хуваарьт зүйл ангид нь зарцуулан сар бүр тайлан мэдээг гаргаж холбогдох газруудад тайлагнан тооцоо нийлж ажилласан. Өөрийн орлого болох ор хоногийн 10%-ийн төлбөрийг төрийн санд төвлөрүүлж ямар нэг зөрчилгүй ажилласан.	100	
Дундаж хувь								100%
Зургаа.Нэмэлт ажил								
(байгууллагын дотоод ажил)								
6.1.1	ТАТХууль	БӨХ	Аймгийн Засаг дарга удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллана.	90%	Үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.	Монгол улсын эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 2/713 дугаар тушаалын дагуу “Малчдад туслах аян”-ыг байгууллагын нийт ажилчид дэмжин 500000 мөнгөн төгрөг хандивлсан.		100

6.1.4	Хог хаягдлын тухай хууль, Аймгийн ИТХ-ын 2019 оны 56 тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны А/312 дугаар захирамж	БӨХ	Нийтийг хамарсан цэвэрлэгээний ажил, хариуцсан талбайн цас, мөсийг цэвэрлэхэд идэвхтэй оролцоно.	50 м хүртэл талбайд	Завхан аймгийн цагдаагийн газрын замын цагдаагийн тасгийн 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 410/18 албан бичгийн дагуу өөрийн хариуцсан цасыг эмч, эмнэлгийн ажилчид цэвэрлэж зөөсөн ба тайланг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлсэн.   Улиастай сумын Засаг даргын 2024 оны	100
-------	---	-----	--	---------------------	---	-----

